Улаанбаатар Монгол

WISH 2025

Улаанбаатар хот дахь судалгаа
2025 оны 7 дугаар сарын 6–наас 7 дугаар сарын 16–ны өдөр хүртэл

Мендрицио хот дахь семинар
2025 оны 7 дугаар сарын 21–нээс 8 дугаар сарын 09–ний өдөр хүртэл

www. wish.usi .ch
@ wish.usi

Workshop on International Social Housing

20 дахь удаагийн хөтөлбөр

Нүүдэлчдийн нийслэл Улаанбаатар хот нь 1639 онд байгуулагдсан ба олон зууны туршид нүүдэлчид, худалдаачдын хөдөлгөөний нөлөөгөөр гол мөрний ай сав дагуу нүүдэллэж, бууриа сэлгэсээр иржээ. Улаанбаатар хот үүсэн байгуулагдсанаас эхлэн иргэдийн сууцны төрөл Монголын уламжлалт гэрээс бүрддэг байсан. Тухайн суурьшсан газар байгаль цаг уурын нөлөө байгалийн тогтоц, малын бэлчээрээс хамаарч нүүдэллэн бууриа сэлгэдэг байв. 1911 онд Монгол Улс Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн тогтоосноор Улаанбаатар хот одоогийн газраа төвхнөж, уламжлалт гэрүүдийн дийлэнх байсан хот Зөвлөлт Холбоот Улсын нөлөөгөөр аажимдаа дэд бүтэц, барилга байгууламж, үйлдвэрүүдтэй болон хөгжиж эхэлжээ.

Өнөөгийн Улаанбаатар хот Туул, Сэлбэ голуудын ай савын дагуу оршдог бөгөөд Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын цогцолбор төв болохын зэрэгцээ нийт хүн амын талаас илүү хувь нь нийслэлд аж төрж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэйгээр бэлчээрийн даац тасралтгүй доройтож, уул уурхайн салбарт тогтвортой ажлын байр нэмэгдсэнээр хөдөө орон нутгаас нийслэл рүү шилжин суурьших иргэдийн тоо жил бүр 20 гаруй мянгаар нэмэгдсээр байна. Хотын хүн амын энэхүү эрчимтэй өсөлт нь орон сууцны хүртээмжийн асуудлыг улам бүр хурцатгаж буйг хотын хойд хэсэгт төвлөрч, хаяа тэлсээр байгаа гэр хорооллууд тод томруунаар харуулна.

WISH төсөл нь Монголд өрнөж буй хотжилтын үйл явц, нөлөөллийг судлах зорилготой бөгөөд орлогод нийцсэн орон сууцны төслүүдийг хэрэгжүүлэхэд уламжлалт сууцны соёл, эдийн засгийн шинэ загвар, байгаль орчны талаарх шинэлэг ойлголтыг уялдуулан авч үзэхийг зорьж байна.

Энэ хүрээнд Università della Svizzera italiana их сургуулийн Архитектурын академийн 10 оюутан, Монгол Улсын ШУТИС-ийн 5 оюутан хамтран Улаанбаатар хотын орлогод нийцсэн нийтийн орон сууцны асуудлыг судлан, гарц шийдлийг тодорхойлох юм. Тэд Улаанбаатар хотод 10 хоногийн турш судалгаа хийж, улмаар Швейцарын Мендрицио хот дахь Архитектурын академид гурван долоо хоногийн турш загварчлалыг тодорхойлохоор ажиллана.

Төсөл хэрэгжүүлэгч:
Accademia di architettura Università della Svizzera italiana

Профессор:
Мартино Педроззи
Туслах багш:
Винченцо Тучилло

Хамтран ажиллагч:
Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)
Архитектурын тэнхим

ШУТИС-ийн профессор:
Доктор Гантөмөрийн Цоводаваа, Барилга архитектурын сургуулийн Архитектурын тэнхмийн эрхлэгч

Швейцарын хөгжлийн агентлаг:
Зөвлөх Лхагвасүрэнгийн Золзаяа

Termine d'inoltro delle candidature:
30 marzo 2025
Presentazione dei workshop:
6 marzo 2025
ore 18:30
aula C3.88

7,5 crediti ects
7,5 credits ects

Accademia di architettura

Con la partecipazione di:
Zolzaya Lkhagvasuren
Consulente della Direzione dello sviluppo e della cooperazione svizzera (DSC)

In collaborazione con:
Mongolian University of Science and Technology (MUST) Department of Architecture
Professore MUST responsabile della co-organizzazione del workshop in Mongolia:
Dr. Tsovoodava Gantumur
Director of the Architecture Department, School of Civil Engineering and Architecture

Un progetto dell'Accademia di architettura dell'Università della Svizzera italiana
Professore:
Martino Pedrozzi
Assistente:
Vincenzo Tuccillo

Workshop on Social Housing

20. Edizione

Fondata nel 1639, Ulan Bator è una capitale nomade che, nel corso dei secoli, si è spostata seguendo i movimenti di mercanti e pastori lungo il corso dei fiumi; era originariamente costituita da un'aggregazione di gher – la tradizione iurta circolare mongola – che effettuavano una migrazione di massa quando il campo era stato sfruttato al limite delle sue possibilità e non offriva più condizioni accettabili per uomini e armenti. Nel 1911, con la proclamazione dell'indipendenza della Mongolia dalla Cina, la città è diventata stanziale e, sotto il dominio sovietico, alle tende hanno cominciato ad affiancarsi gradualmente infrastrutture, palazzi e industrie.

Oggi Ulan Bator, situata sulla riva destra del fiume Tola, rappresenta il principale centro politico, culturale ed economico del paese e ospita circa metà della popolazione mongola; i suoi abitanti continuano a crescere al vorticoso ritmo di ventimila all'anno sospinti dalla steppa verso la capitale dall'implacabile diminuzione dei pascoli causata dai cambiamenti climatici e dalla complementare offerta di un lavoro stabile legato alla fiorente industria mineraria. Una fotografia di questa tumultuosa dinamica demografica è la distesa a perdita d'occhio di iurte nomadi che si addensano a nord della città e che pongono sempre più urgenti interrogativi in termini di alloggio sociale.

WISH si propone di approfondire il fenomeno dell'inurbamento all'interno dello straordinario contesto naturale mongolo lavorando – nell'affrontare progetti di alloggio collettivo – all'intersezione tra tradizioni abitative millenarie, nuovi modelli economici e una rinnovata sensibilità ambientale.

Dieci studenti dell'Accademia di architettura dell'Università della Svizzera italiana e cinque studenti della Mongolian University of Science and Technology affronteranno il tema dell'alloggio collettivo a Ulan Bator. Il gruppo parteciperà ad un viaggio di studio a Ulan Bator di 10 giorni circa al quale seguirà un workshop di progettazione della durata di 3 settimane a Mendrisio, presso l'Accademia di architettura.

Ulaanbaatar Mongolia

Workshop a Ulan Bator
6 — 16.07

Workshop a Mendrisio
21.07 — 9.08